



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 4/456

Арвайхээр сум

Хариуцлага, үр дүн тооцох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1.3, 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарын ажлын үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн сахилга батгүй, хариуцлагагүй ажиллаж 2022 оны төрийн аудитын дүгнэлтээр зөрчилтэй болон алдаа зөрчлийг давтан гаргасан 1 дүгээр хавсралтад дурдсан албан хаагч нарт сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Төсвийн зөрчил, дутагдалгүй ажилласан төсвийн захирагч, сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч нарын урамшууллын хэмжээг 2 дугаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон орон нутгийн төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нарын урамшууллын хэмжээг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн 2 болон 3 дугаар хавсралтаар олгох урамшууллыг тухайн байгууллагын батлагдсан төсөвт багтаан олгож, өр төлбөр үүсгэхгүй ажиллахыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт даалгасугай.

4. Уг захирамжаар хариуцлага болон урамшуулал тооцсон албан тушаалтнуудаас бусад сумын төрийн сангийн мэргэжилтэн, орон нутгийн нягтлан бодогч нарт санхүүгийн тайлангийн дүгнэлт, гарсан алдаа зөрчил, ажлын үр дүнг үндэслэн хариуцлага, үр дүнг тооцож ажиллах, авсан арга хэмжээний хариуг 9 дүгээр сарын 15-ны дотор албан тоотоор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т, төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0886

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 17 дугаар
сарын 07-ны өдрийн 17/17 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



ТӨСВИЙН ЗАХИРАГЧ, СУМЫН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
НАРТ ОЛГОХ УРАМШУУЛАЛ

(үндсэн цалингийн)

Д/д	Сумын нэр	Засаг дарга	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	Сумын ерөнхий нягтлан бодогч
1	Баян-Өндөр	1 сарын		1 сарын
2	Бат-Өлзий	1 сарын		1 сарын
3	Баянгол	1 сарын		1 сарын
4	ЗБУлаан	1 сарын		1 сарын
5	Сант	1 сарын		1 сарын
6	Төгрөг	1 сарын	1 сарын	1 сарын
7	Хайрхандулаан	1 сарын		1 сарын
8	Хужирт	1 сарын		1 сарын
9	Хархорин	1 сарын	1 сарын	1 сарын
10	Арвайхээр	1 сарын		1 сарын

-оОо-